



"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар: 22/06

Улаанбаатар
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60, 62, 64, 65, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах.
 - 2.2. ТҮЗ-ийн 2022 оны зардлын төсвийг хэлэлцэн батлах.
3. Компани нь сүүлжийн жилүүдэд бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөн чадаагүй тул 2021 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
4. Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр, 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрүүдэд өдөр тутмын сонин хэвлэл болон телевиз, радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэхээр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тасалбар болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг брокер дилерийн компаниудаар дамжуулан тараахыг зөвшөөрсүгэй.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөр тасалбар болгож, брокер дилерийн компани болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө-67/1 тоот хаягт буюу "Номин юнайтед" цогцолборын 5-р давхарт тус тус хүлээж авахаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга С.Сайнбатыг томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Эдийн засагч, ахлах нягтлан бодогч Баатаржавын Даваасүрэнг, тооллогын комиссын гишүүдээр хуульч Энхболдын Төгсжаргал, хуульч Батмөнхийн Сансар нарыг томилсугай.
12. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал И.Галбуянг, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөлийг бүрдүүлж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын гишүүдэд үүрэг болгосугай.





“Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 03-р сарын 18-ны
өдрийн хурлын 22/06 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас

- Хурал хуралдах газар /хаяг, байршил/: Хурал цахим хэлбэрээр болно.
- Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:
- Хувьцааны тоо: Регистр №
- Хурлаар шийдвэрлэх асуудлууд:
1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах.
 - a. Зөвшөөрсөн
 - б. Татгалзсан
 - в. Түдгэлзсэн
 2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг батлах.
 - a. Зөвшөөрсөн
 - б. Татгалзсан
 - в. Түдгэлзсэн

Санамж:

1. Санал өгөгч нь өгөх саналынхаа өмнөх үсгийг дугуйлна.
2. Саналын хуудсыг балласан, засварласан бол хүчингүйд тооцно.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

2022/ / /

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд тооцсон:

Тооллогын комиссын дарга: _____

Гишүүд:
